



Аудитын ерөнхий дүгнэлт: Төв аймагт 2012 оноос хойш 6 байгууллага шинээр байгуулагдаж, 75 орон тоо нэмэгдсэн байна.

Аудитын нэр:

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨРИЙН ДЭЭД
БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ**

**Зуунмод
2014 он**

АГУУЛГА

YAG-НАГ/2014/ 09-НА-ТӨ

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар.....3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4-5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын дүн.....
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ -1
Аудитор О.Сосор Ж.Бямбацогт	Дүгнэлт 1
	<i>Орон нутагт төрийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байгаа ч шинээр байгууллагууд нэмэгдсээр байна.....6-12</i>
	БҮЛЭГ- 2
2014 оны 09 дугаар сарын 20	Дүгнэлт 1
	<i>Зарим байгууллагуудын төсвийн төлөвлөлт үндэслэл муутай байна.....13-15</i>
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	Дүгнэлт..... 16
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 7027-2582 дугаарын факсаар харилцана уу.	Зөвлөмж.....17
ХАЯГ:	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....16
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ААГ	Аймгийн аудитын газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ССАЖГ	Соёл спорт аялал жуулчлалын газар
ҮХААГ	Үйлдвэр хөдөө аж ахуйн газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОБГ	Онцгой байдлын газар
СХЗХ	Стандарт хэмжил зүйн хэлтэс
НХҮХ	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
ХГБХХ	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба
ТАЗГ	Тээвэр авто замын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БОГ	Байгаль орчны газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
БТСБСТ	Биеийн тамир спорт бэлтгэл, сургалтын төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны даргын 2014 оны 1-р сарын 28-ны 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Монгол улсын Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, төрийн дээд байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилт, төрийн захиргааны зардлыг бууруулах ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

- Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх яам, агентлаг, байгууллага, орон нутгийн ЗДТГ, ИТХ, Улсын төсөвт үйлдвэрийн газар, төвийн бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой байдлаар хууль тогтоомжид нийцүүлж зохион байгуулсан эсэх
- Зарим яам, агентлаг, байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох замаар төсвийн хөрөнгө хэмнэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх боломж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ: Аудитаар Төв аймгийн агентлагууд, сумдын ЗДТГ, ИТХ Баг, Улсын төсөвт үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолт, 2013 оны тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Яамны эрх зүйн тухай хууль
- Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хууль

-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

-Засгийн газрын 2008 оны 67-р тогтоол

Засгийн газрын 2011 оны 20-р тогтоол

Засгийн газрын 2003 оны 233-р тогтоол

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, Аудитор О.Сосор, Ж.Бямбацогт нар 2014 оны 08-р сарын 27-ноос 09-р сарын 20-ныг хүртэл хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх яам, агентлаг, байгууллага, орон нутгийн ЗДТГ, ИТХ, Улсын төсөвт үйлдвэрийн газар, төвийн бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой байдлаар хууль тогтоомжид нийцүүлж зохион байгуулсан эсэх

Бүлэг 1

Орон нутагт төрийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байгаа ч шинээр байгууллагууд байгуулагдаж орон тоо нэмэгдсээр

1.1. Төв аймгийн төрийн байгууллагууд Засгийн газраас тогтоосон орон тооны дээд хязгаарыг баримтлан ажиллаж байгаа хэдий ч зарим байгууллагууд орон тоо хэтрүүлэн ажилласан байна.

Төв аймаг нь 88399 хүн амтай, 27 сум 97 багтай. Аудитад аймаг, сумдын ИТХурал, ЗДТГазар, 20 агентлаг хамрагдсан.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тоог Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.3-д “Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Тэргүүлэгчид өөрөө тогтооно” гэж заасны дагуу Төв аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2013 оны 05-р сарын 16-ны өдрийн 64 дугаар тогтоолоор ажлын албаны дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 8, жолооч 2, бүгд 12 хүнтэй байхаар шинэчлэн тогтоосон байна. Аймгийн ИТХ-ын орон тоо нь 2012 онд 7, 2013 онд 10 байсан бол 2014 оны эхний хагас жилд 12 болж нэмэгдсэн байна.

Аймгийн 25 сумдын ИТХ нь дарга, нарийн бичгийн дарга гэсэн 2 орон тоотой ажиллаж байгаа бол Заамар сумын ИТХ-ын ажлын алба 3 орон тоотой, Зуунмод сумын ИТХ-ын ажлын алба 4 орон тоотой ажиллаж байна.

Аймгийн НДХэлтэс, ОБГазар, СХЗХэлтэс, НХҮХэлтэс, ХГБХХэлтэс, Цагдаагийн газар, ШШГАлба, Шүүхийн шинжилгээний алба, Хөдөлмөрийн хэлтэс, ХАААлба, Татварын хэлтэс, ССАЖГазар, ГХБХБГазар, Боловсролын газар, МХГазар зэрэг байгууллагууд батлагдсан бүтэц, орон тоондоо ажиллаж байна. Аймгийн ЗДТГазар, Зуунмод сумын ЗДТГазар, БОГазар, Статистикийн хэлтэс, ТАЗГазар, ЭМГазар, ҮХААГазар зэрэг байгууллагууд батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд ажиллаагүй байна.

2012 онд болсон орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан аймгийн ИТХурал, түүнээс нэр дэвшүүлэн томилогдсон Засаг дарга ажиллаж эхэлснээс хойш аймгийн Засаг дарга 2 орлогчтой ажиллаж байна. Энэ нь ЗГ-ын 2008 оны 67 дугаар тогтоолын 1-д “Аймгийн удирдлагыг Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга байхаар тогтоосугай” гэснийг зөрчсөн байна. Мөн түүнчлэн ЗГ-ын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолын 3 дах заалт хэрэгжихгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор Аймгийн удирдлага болон ЗДТГ-ын бүтцийг тогтоож, 41 орон тоотой ажиллахаар баталсан байна. Аймгийн Засаг даргын 2013 оны 12 сарын 30-ны өдрийн А/698 дугаар

захирамжаар Аймгийн ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг 41 орон тоотой байхаар тогтоож, ЗДТГ-ын даргын 2013 оны 12 сарын 31-ний өдрийн А/169 дугаар тушаалаар ЗДТГ-ын бүтэц, орон тоог 37 байхаар баталсан байна. 2014 оны эхний хагас жилийн байдлаар ЗДТГ-ын бүтэц орон тоонд багтаагүй дайчилгааны офицер, орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер ажиллаж байна. Дээрх албан тушаалууд нь Төрийн албаны тухай хуулийн 11.2-т заасан төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд Аймгийн Засаг даргын баталсан орон тооны хязгаарт багтаж байгаа ч аймгийн ЗДТГ-ын даргын баталсан орон тооноос хэтэрч, Төсвийн тухай хуулийн 16.5.3, 16.5.5 дах заалтыг зөрчиж дүйцүүлэх албаны зардлаас цалинжуулж байна.

ЗДТГ-ын даргын 2013 оны 03 сарын 01-ний өдрийн Б/24 дугаар тушаалаар Иргэний танхимын менежер 1, оператор 3, нийт 4 хүнийг томилж 2014 оны эхний хагас жилийн байдлаар сургалт семинарын зардлаас 11140.4 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Албан бус боловсролын төвийг аймгийн “Насан туршийн боловсролын төв” болгон, сумдын “Гэгээрэл төвийг” Насан туршийн боловсролын нэгж болгон 2013 оны 11-р сарын 01 нээс эхлэн бүтэц орон тоог Аймгийн Засаг даргын 2013 оны 11-р сарын 13 өдрийн А/608 тоот захирамжаар баталсан байна. Насан туршийн боловсрол төвийн бүтцийг 6 орон тоотой баталсан боловч зардал, санхүүжилт нь батлагдаагүй байна. “Насан туршийн боловсролын төв” байгуулсан боловч санхүүжилтийг шийдээгүйгээс 2014 оны эхний хагас жилд Боловсролын газраас 3077.2 мянган төгрөг, аймгийн хувиарлагдаагүй зардлаас 8250.4 мянган төгрөг, нийт 11732.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, үйл ажиллагаа явуулсан байна. Тус байгууллага нь Төрийн банкинд данстай, аж ахуй нэгжийн тайлан тэнцэл гаргасан байна.

Дээрх 2 байгууллагыг харьяалал, статус, санхүүжилтийн эх үүсвэрийг нь тодорхой бус явж ирсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 20-р тогтоолыг үндэслэн Төв аймгийн Засаг даргын 2012 оны 05-р сарын 23 ны өдрийн а/324 тоот захирамжаар 27 сумдын удирдлага болон ЗДТГ-ын бүтэц орон тоог хүн амын тооноос хамааран тогтоосон байна. Засгийн газрын 2011 оны 20-р тогтоолоор сумдын ЗДТГ-ын үйлчилгээний зарим ажилтнуудын орон тоо батлаагүй тул аймгийн Засаг даргын дээрхи захирамжаар сумдын ЗДТГ-ын гэрээт ажилтнуудын тоог сумдад 4-6 орон тоо, нийт 129 орон тоогоор ажиллахаар баталсан байна. Сумдын ЗДТГазар нь батлагдсан орон тоондоо ажиллаж байгаа боловч интернэт мэдээллийн ажилтны орон тоо бүтцэд орж батлагдаагүйгээс гэрээт ажилтнаар цалинжуулан ажиллаж байна.

Зуунмод сумын Засаг даргын 2013 оны 01-р сарын 18-ны өдрийн а/18 тоот захирамжаар Зуунмод сумын ЗДТГазар, Захирагчийн албаны орон тооны хязгаар, албан тушаалын бүтцийг өөрчлөн шинэчлэн тогтоож 21 орон тоогоор баталсан байна. Тооны хувьд батлагдсан орон тоонд байгаа хэдий ч албан тушаалын нэрийг өөрчилсөн байна. Сумын Засаг даргын орлогчийг 2 болгосон нь ЗГ-ын 2008 оны 67 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Энэ зөрчлийг 2014 оны хагас жилээр арилгаж Засаг даргын орлогч 1 болгосон байна. Мөн түүнчлэн мал эмнэлэг үржлийн тасгийн 3 орон тооноос 2 орон тоог хасч дотоод ажил, хяналт үнэлгээ хариуцсан

мэргэжилтэн, нийгмийн хөгжлийн мэргэжилтэн гэсэн 2 орон тоо нэмсэн нь “Монгол мал үндэсний хөтөлбөр”- ийн хүрээнд сумдад Мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай Засгийн газрын 2010 оны 223-р тогтоолыг зөрчсөн байна.

Сумдын баг тус бүрт багийн дарга орон тоогоор ажилладаг. Хүн амын нягтралаас хамаарч багийн зохион байгуулагч ажилтан Батсүмбэр, Жаргалант, Заамар сумдад 1, Зуунмод суманд 6 ажиллаж байна. Сумдын хүн амын тоог, багийн тоонд харьцуулсан судалгаа хийсэн. Судалгаагаар нэг багийн даргад Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Зуунмод суманд 1260-2500 хүн ноогдож байхад, Сэргэлэн, Баянжаргалан, Баянцагаан, Өндөрширээт, Цээл сумдад 370-520 иргэн ноогдож байна. Үүнээс үзэхэд багийн дарга нарын ажлын ачаалал, иргэдэд үзүүлэх үйлчилгээ, харилцан адилгүй байна./судалгааг хавсаргав/

Аймгийн БОГазарт сумдын байгаль хамгаалагч батлагдсан орон тооноос 3 илүү ажиллаж байна. Мөн түүнчлэн Засгийн газрын 2013 оны 146-р тогтоолоор Байгаль орчны газар нь ус цаг уур орчны шинжилгээний албатай байна гэж заасан боловч одоог хүртэл УЦУОШТөв нь тусдаа төсөвтэй, тамга тэмдэгтэй ажиллаж байна. Засгийн газрыг тогтоолыг хэрэгжүүлэх талаар эрх бүхий байгууллагаас ямар нэг арга хэмжээ авагдаагүй байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны бүтцийг аймгийн Засаг даргын 2011 оны 04 дүгээр сарын 05-ний өдрийн А/159 тоот захирамжаар 70 орон тоотой ажиллахаар баталсан байна. Төв аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн б/11 тоот тушаалаар 62 орон тоотой ажиллахаар баталсан байна. Энэ нь нийт дүнгээрээ аймгийн Засаг даргын баталсан орон тооноос бага байгаа боловч Эрүүл мэндийн Сайдын тушаалаар үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан орон тооноос 11 орон тоог илүү ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын бүтэц орон тоо баталсан захирамж, Эрүүл мэндийн яамны сайдын бүтэц орон тоо баталсан тушаал хоорондоо зөрчилдөж байна.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 415 тоот тогтоолоор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар болгон өөрчилсөн бөгөөд аймгуудын Үйлдвэр, хөдөө аж ахуйн газруудын орон тооны хязгаарыг 15-40 байхаар тогтоосон байна. Энэхүү тогтоолын хүрээнд Монгол улсын Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/170 тоот тушаалаар Төв аймгийн ҮХААГ-ын бүтэц, орон тоог 28 тогтоосон байна. Гэвч Лүн сумын хяналтын цэгийг байгуулан 12 орон тоо нэмж, нийт 39 орон тоогоор ажиллаж байгаа нь Засгийн газар, ҮХААГ-ын сайдын тушаалаар баталсан орон тооны дээд хязгаараас хэтэрсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 247 тоот тогтоолоор Лүн суманд хорио цээрийн хяналтын цэгийг байгуулахаар шийдвэрлэн, мэргэжлийн хяналтын улсын байцаагч, цагдаагийн албан хаагч, мал эмнэлгийн улсын байцаагч зэрэг албан хаагч нар хамрагдахаар заагдсан байна. Гэвч Лүн суман дахь хяналтын цэг дээр ажиллах төрийн албан хаагчдын бүтэц, орон тоо санхүүжилтийг шийдвэрлээгүй аймгийн ҮХААГ-ын цалингийн санг нэмэгдүүлснээс тус байгууллагын орон тоон хэтрэх үндэслэл болсон байна.

Төв аймгийн Боловсролын газар, ССАЖГазар, Татварын хэлтэс, НДХэлтэс, ЭМГазар зэрэг байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, орон тоог албан

тушаалын ангилал, зэрэглэл баталсан харьяалах дээд байгууллагын тушаал шийдвэр ирээгүй, зөвхөн төсвийг баталж, орон тооны хязгаарыг тогтоосон байна. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.4-д “батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох”; гэсний дагуу бүтэц орон тоог баталсан шийдвэрүүдийг ирүүлээгүй байна.

1.2 Орон нутагт төрийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байгаа ч шинээр байгууллагууд нэмэгдэж орон тоо, төсөв өссөөр байна.

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 14 дүгээр тогтоолоор яамдын бүтэц орон тоо хязгаарыг баталсан. Дээрх шийдвэрийн дагуу орон нутагт ХАААлба, Хөдөлмөрийн хэлтэс, ССАЖГазар шинээр байгуулагдсан байна.

№	байгууллагын нэр	шийдвэр			орон тоо
		нэр	огноо	дугаар	
1	Худалдан авах ажиллагааны алба	ЗГ-ын тогтоол	12.12.01	144	4
2	Хөдөлмөрийн хэлтэс	ЗГ-ын тогтоол	12.09.15	36	28
3	ССАЖГазар	ЗГ-ын тогтоол	13.04.20	146	11
4	Биеийн тамир спорт бэлтгэл сургалтын төв	Аймгийн ЗД-ын захирамж	14.01.14	А/16	16
5	Насан туршийн боловсрол төв	Аймгийн ЗД-ын захирамж	13.11.13	А/608	4
6	Дотоод аудит хяналт шинжилгээний алба	Аймгийн ЗД-ын захирамж	13.12.31	Б/699	5

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 32 дугаар тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийг “Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс” болгож өөрчилсөн байна. Хөдөлмөр, халамжийн хэлтэс байхдаа 2012 онд 39 орон тоотой байсан бол Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2013 оны 01 дүгээр сарын 09-ний 09 тоот тушаалаар 50 орон тоотой байхаар батлагдаж, 11 орон тоогоор нэмэгдсэн байна.

ЗГ-ын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөж Хөдөлмөрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан Засгийн газрын 2012 оны 36 тоот тогтоолоор аймаг, нийслэлийн дүүрэгт Хөдөлмөрийн хэлтэс байгуулагдаж, хүн амын төвлөрөл, үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоог харгалзан орон тооны хязгаарыг 30 хүртэл байхаар тогтоосон байна. Хөдөлмөрийн сайдын тушаалын дагуу Төв аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн 2013 оны бүтэц, орон тоог Захиргаа санхүүгийн алба 9, Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн харилцааны алба 12, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний алба 7, нийт 28 орон тоотой ажиллахаар тогтоосон байна.

Засгийн газрын 2012 оны 12-р сарын 01-ний өдрийн 144-р тогтоолоор Худалдан авах ажиллагааны алба шинээр байгуулагдсан. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллаж байна. Худалдан

авах ажиллагааны газраас 4 орон тоотой ажиллуулах зөвлөмжийн дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь 2013-2014 онд дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, нягтлан бодогч гэсэн орон тоогоор ажиллаж байна.

Засгийн газрын бүтэц бүрэлдхүүн өөрчлөгдөж салбарын яамд шинээр байгуулагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг зарим агентлагуудын чиг үүрэгт өөрчлөлт орсон тул Аймгийн Засаг даргын 2013 оны 8-р сарын 26 ны өдрийн А/464 тоот захирамжаар Биеийн тамир спортын газрыг татан буулгаж ССАЖГ-ыг 2013.08.26 ны өдрөөс байгуулсан байна. ССАЖСайдын 2013 оны 05 сарын 03-ны а/1469 тоот зөвлөмжийн дагуу Аймгийн Засаг даргын 2014 оны 01-р сарын 14-ний өдрийн А/16 тоот захирамжаар ССАЖГ-ын харьяа Биеийн тамир, спорт бэлтгэл, сургалтын төв гэсэн байгууллагыг байгуулж бүтэц, орон тоог баталсан. Дээрхи захирамжийн хавсралтаар ССАЖГазарт 11 орон тоо, Биеийн тамир спорт бэлтгэл, сургалтын төвд 16 орон тоо батлагдсан байна. 2013 онд БТСГазар 22 орон тоотой ажиллаж байсан бол ССАЖГ, БТСБСТөв нь 27 орон тоогоор ажиллаж орон тоо өмнөхөөс оноос 5 ажилтанаар нэмэгдсэн байна.

Аймгийн ЭМГазрын орон тоог хүрэлцээтэй баталж өгсөнтэй холбоотойгоор нэг чиглэлийн ажлын байранд 2-3 хүн ажиллуулж байна. Тус байгууллага нь хүний нөөцийн мэргэжилтэн 2, архив бичиг хэргийн ажилтан, эрхлэгч 3 хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан, албан хаагчдийн ажлын байрны тодорхойлолт зэргийг татан авч шалгахад чиг үүргийн давхардалгүй байна.

1.3 Байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж байгаа зөрчил байна.

Аймгийн Засаг даргын 2012 оны 05 сарын 23-ны өдрийн А/324 дугаар захирамжийн 6-р хавсралтаар 27 сумын ЗДТГ-ын болон багийн үйлчилгээний ажилтны /гэрээт/ тоог сумдаар нь баталсан. Сумдын ЗДТГ-ын гэрээт ажилтны орон тооны дээд хязгаарыг 129 орон тоогоор тогтоосон байна. Сумдын ЗДТГ-т 2013 онд 145 гэрээт ажилтан ажилласан байгаа нь тогтоосон орон тооны хязгаараас 16 гэрээт ажилтан илүү ажилласан байна. 2014 оны эхний хагас жилийн байдлаар 129 гэрээт ажилтан ажиллаж байна.

Төв аймгийн 27 сумаас 18 суманд интернет мэдээллийн ажилтаны орон тоо батлагдаагүй тул интернет мэдээллийн ажилтан гэсэн байнгын ажлын байранд гэрээт ажилтнууд ажиллаж байна. Мөн Тээвэр авто замын газарт 9 тээвэр зохицуулагч, Статистикийн хэлтэст салбар хариуцсан 2 мэргэжилтэн нь байнгын ажлын байранд гэрээтээр ажиллаж байна.

Аймгийн агентлагуудад жижүүрийн орон тоог гэрээт ажилтнаар төлөвлөсөн байна. 2014 оны эхний хагас жилийн байдлаар НДХэлтэс, Онцгой байдлын хэлтэс, СХЗХэлтэс, ХГБХХэлтэс, Нийгмийн халамжийн хэлтэс, ҮХААГ зэрэг байгууллагууд нь нэг байгууллагад 24 гэрээт ажилтан ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 22 гэрээт ажилтнууд ажиллаж байна.

Төрийн албыг боловсронгуй болгох, төсвийн зардлыг хямдруулах ажлын хүрээнд төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зорилгоор Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоол батлагдсан. Гэвч энэ тогтоол орон нутагт хэрэгжилгүй өдийг хүрч, холбогдох эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тогтоолыг хэрэгжүүлэх талаар ямар нэг арга хэмжээ аваагүй байна. Төв аймгийн төрийн байгууллагууд нь гэрээгээр гүйцэтгүүлэх зарим ажил үйлчилгээг төрийн үйлчилгээний албан хаагчдаар гүйцэтгүүлж байна.

Зарим яам, агентлаг, байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох замаар төсвийн хөрөнгө хэмнэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх боломж байгаа эсэх

Бүлэг 2

Зарим байгууллагуудын төсвийн төлөвлөлт үндэслэл муутай байна.

2.1 Төв аймгийн ИТХ, ЗДТГ, агентлагууд болон сумдын ИТХ, ЗДТГ нь өөрийн байгууллагын чиг үүрэгт заасан ажил үйлчилгээ явуулж байна.

Төв аймгийн ИТХурал, ЗДТГазар, агентлагууд болон сумдын ИТХурал, ЗДТГазар нь өөрийн байгууллагын чиг үүрэгт заасан ажил үйлчилгээ явуулж байна. Үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажил үйлчилгээ эрхэлсэн байгууллага байхгүй байна.

ЗГ-ын 2008 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн ЗДТГ-ын бүрэлдэхүүнд багтах хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийг татан буулгаж Аймгийн Засаг даргын 2013 оны 12 сарын 31-ний өдрийн Б/699 дугаар захирамжаар хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албыг 5 орон тоотой байгуулсан байна.

ЗГ-ын 2012 оны 129 дүгээр тогтоолоор Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэлд төсвийн хөрөнгийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, төрийн сангийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд аудит хийнэ гэж заасан байхад Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын алба нь ЗГ-ын тогтоол шийдвэр, ИТХ-ийн шийдвэр, Засаг даргын захирамжийн биелэлт, төрийн алба, хүний нөөц болон хэлтэс агентлагийн дотоод ажил, үйл ажиллагааны төлөвлөлтөд хяналт шинжилгээ үнэлгээ хийж байгаа нь дотоод аудитын дүрэмд заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.

2.2 Зарим байгууллагуудын төсвийн төлөвлөлт үндэслэл муутай байна.

Аймаг, сумын Засаг дарга, тухайн шатны төсвийн төслийг боловсруулж, төсвийн суурь зарлагыг тооцохдоо Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйл, Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай Засгийн газрын 30-р тогтоол, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах тухай Сангийн сайдын 244 тоот баталсан журам зэрэг эрх зүйн баримтуудыг үндэслэн тооцсон байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийг Аймгийн ИТХ-аар хэлэлцэж батлуулдаг тул төсөв бодитой төлөвлөгдөж байна. Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд буюу улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын хувьд төсвийн төлөвлөлт үндэслэл хангалтгүй байна. Цалингийн хэмнэлт нилээд гарч байгаа нь орон тоо, цалингийн санг уялдуулдаггүй, цалингийн зардлын тооцоо, төлөвлөлтийг үндэслэл муутай хийгдсэн холбоотой байна.

2013 оны Цалингийн сангийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал
/ сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Цалингийн сан		Хэмнэлт хэтрэлт
		Батлагдсан	Гүйцэтгэл	
1	ГХБХБГазар	140.1	135.7	4.4
2	ҮХААГазар	311.8	207.1	104.7
3	НДХэлтэс	436.6	432.4	4.1
4	НХҮХэлтэс	373.3	373.1	2.2
5	ОБГазар	529.7	516.3	13.4
6	Хөдөлмөрийн хэлтэс	161.9	154.7	7.2
7	Статистикийн хэлтэс	64.2	64.2	0
8	ТАЗГазар	100.0	78.9	21.1
9	Цагдаагийн газар	1 648.1	1 601.8	46.3
10	Шүүх шинжилгээний алба	123.3	121.3	2.0
11	Татварын хэлтэс	454.3	466.3	(12.0)
12	УЦУОШГазар	744.3	744.2	0.1
Дүн	Хэмнэсэн			203.4
	Хэтэрсэн			(12.0)

Дээрх судалгаанаас үзэхэд аймгийн 2013 оны эцэст Татварын хэлтсээс бусад улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын цалингийн зардал хэмнэлттэй гарсан байна.

Аймгийн Тээвэр авто замын газрын цалингийн санг орон тоотой нь уялдуулаагүйгээс 2014 онд төлөвлөгөөгөөр гэрээтээр 5 ажилтан ажиллахаас гүйцэтгэлээр 9 ажилтан ажиллаж байна.

ҮХААГазар 2013 онд цалингийн сан төлөвлөгөөгөөр 311795.3 мянган төгрөг байснаас 207055.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 104739.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Цалингийн сан хэмнэлттэй гарсан нь зарим, мэргэжлийн орон тоо болон Лүн суман дахь хорио цээрийн хяналтын цэгт ажиллах албан хаагчдын ихэнхийг оны сүүлийн хагас жилд авсантай холбоотойгоор цалингийн сан хэмнэгдсэн.

Статистикийн хэлтэс нь 2013 оны жилийн эцэст 7180.0 мянган төгрөгийн цалингийн хэмнэлт гарсныг байгууллагын даргын тушаалаар ажил хавсарсан, үр дүнгийн урамшуулал хэлбэрээр олгож зарцуулсан байна.

Улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын цалингийн санг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоотой нягт уялдуулан ажиллавал цалингийн сангийн төсөв хэмнэгдэх боломжтой байна.

2.3 Байгууллагууд нэмэгдсэнээр төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 09 р сарын 18 ны өдрийн 37-р тогтоолоор Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн баталсан. Дээрхи хөтөлбөрт тусгагдсан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл, оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрүүдийг Хөдөлмөрийн хэлтэс хэрэгжүүлж байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийн хүрээнд 100 ахмадад 22400.0 мянган төгрөгийн санхүүжилт, сумын залуус төсөлд 108 оюутанд 21600.0 мянган төгрөг, ажлын гараа төслийн хүрээнд 115 ажилгүй залуучууд түр ажлын байраар хангаж 23000.0 мянган төгрөгийн цалин, эзэнтэй монгол хөтөлбөрийн хүрээнд 781 ажил олоход хүндрэлтэй иргэн түр ажлын байранд хамрагдаж 133764.0 мянган төгрөгийн цалин олгогдсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ зохион байгуулж 32 шинэ ажлын байр буюу байнгын ажлын байр бий болгон 30000.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

ХЭДСангийн зээл 500.0 сая төгрөг хуваарилж ирснийг 27 сумын 127 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 275.8 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

2014 онд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчин өрхийг хамруулан байнгын 100 ажлын байр бий болгон 208556.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Аймгийн даргын орлогч 2 ажиллаж байгаа нь ЗГ-ын 67-р тогтоолыг зөрчсөн байна.
2. Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албанд томилогдсон аудитор, шинжээчид нь ЗГ-ын 2012 оны 129 дүгээр тогтоолын “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.6 дахь заалтанд заасан шаардлагыг хангаагүй ажилтнууд ажиллаж байна.
3. 27 сумаас 18 суманд интернет мэдээллийн ажилтаны орон тоо батлагдаагүй тул интернет мэдээллийн ажилтнууд гэрээт ажилтнаар ажиллаж байна.
4. Аймгийн Засаг даргын бүтэц орон тоо баталсан захирамж, Эрүүл мэндийн яамны сайдын бүтэц орон тоо баталсан тушаал хоорондоо зөрчилдөж байна.
5. Боловсролын газар,Татварын хэлтэс, НДХэлтэс, ССАЖГ-ын бүтэц орон тоог баталсан шийдвэр харьяалах дээд байгууллагаас ирээгүй байна.
6. Улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын цалингийн санг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоотой нягт уялдуулан ажиллавал цалингийн сангийн төсөв хэмнэгдэх боломжтой байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн
Аймгийн Засаг дарга Д.Баярбатад зөвлөх нь:

- Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 67-р тогтоолыг баримтлан, Засгийн Газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэн Засаг даргын орлогчийн орон тоог шийдвэрлэх.
- Иргэний танхим, Насан туршийн боловсрол төв зэрэг байгууллагуудын статус, харьяалалыг тодорхой болгож төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх.
- Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын албаны үйл ажиллагааг дотоод аудитын дүрэмд заасан чиг үүргийн дагуу ажиллуулах
- Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоо баталсан Аймгийн Засаг даргын захирамжийг Эрүүл мэндийн сайдын бүтэц орон тоо баталсан тушаалтай нийцүүлэх.

Аймгийн ЗДТГазрын дарга Д.Нямдорж-д зөвлөх нь :

- ЗДТГ-ын бүтэц орон тоонд багтаагүй дайчилгааны офицер, орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер ажиллаж дүйцүүлэх албаны зардлаас цалинжуулж байгааг таслан зогсоож орон тоо цалингийн санг шийдвэрлэх

Аймгийн Статастикийн хэлтсийн дарга Ж.Отгончулуун, Тээвэр, авто замын газрын дарга А.Бат-Эрдэнэ нарт зөвлөх нь:

- Төрийн албан хаагчийн байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж байгаа зөрчлийг арилган хуулийн дагуу шийдвэрлүүлэх

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


**МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**
21300 Зуунамд, Төв аймэг
Утас/Факс: 70233705, И-мэйл: tov_singgiin.mn

2014-09-22 № 1/078
тунхаг 2014-09-17 -ны № 03/178

АУДИТЫН ГАЗАРТ

Манай байгууллагад хийгдсэн нийцлийн
аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг
хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудас

ДАРГА  Ч.АЛТАНТУУЛ

D:\Alban bichig\toot\A5-



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41100, Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70273087

2014.09.23 № 03/1452
талан 2014.09.19, -ны № 03/150 -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Л.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА**

**Тайлангийн төсөлд тайлбар
гаргах тухай**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013 оны А/169 дүгээр тушаалаар Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн тогтоосон. Энэхүү тушаалаар аймгийн ЗДТГ нийт 37 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Нэг. Дараахь албан тушаалууд нь аймгийн ЗДТГ-ын үндсэн бүтцэд ордоггүй, бусад эх үүсвэрээс цалинждаг болно. Үүнд:

1.Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Сангийн нягтлан бодогч нь аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон "Байгаль хамгаалах сан"-гаас цалинжиж байна.

2.Цэрэг, иргэний дайчилгаа, сургалт сурталчилгааг орон нутагт зохион байгуулах Дайчилгааны офицер, Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер нар нь Дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос цалинжиж байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудын хэрэгжилт, төр захиргааны байгууллагаас зохион байгуулж буй үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх зорилгоор аймгийн Иргэний танхимыг 2013 оноос байгуулан ажиллаж байна. Энэ ажлыг орон нутагт санаачилан хэрэгжүүлсэн нь Төв аймгийг 2013 онд "Шилдэг аймаг" болоход нөлөөлсөн олон амжилтуудын нэг юм.

Иргэний танхимын 4 ажилтан нь мэдээлэл сурталчилгааны зардлаас цалинжиж, хууль тогтоомж, орон нутгийн бодлого шийдвэр, төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хэлэлцүүлэг явуулах, санал хүсэлт хүлээн авч, хариу өгөх ажлын эрхлэж байна.

Гурав. Төв аймаг нь 2014 оны байдлаар Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны 4 орны 4 муж, Зүүн өмнөд Азийн бүс нутгийн аялал жуулчлалын 11 оронтой шууд харилцаатай ажиллаж байна.

Эдгээр улс орон, мужуудтай харилцаа хамтын ажиллагаа жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд нэг хүнд ногдох ажлын ачаалал нэмэгдсэн тул аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн тул Засаг даргын Тамгын даргын шийдвэрээр гадаад харилцааны мэргэжилтэнг 2 байхаар баталсан юм.

Дөрөв. Аймгийн Хяналт, Шалгалт, Үнэлгээ, Дотоод аудитын алба нь аймгийн ЗДТГ-ын үндсэн бүтэцд багтахгүй. Аймгийн Засаг даргын дэргэдэх тусдаа алба учир тайлангийн төсөлд тусгагдсан хэсгийг тус албанд хүргүүлэх нь зүйтэй.

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



С.ЦОГБАЯР



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213300 Зуунмод, Төв аймга
Утас: Факс:

2014.09.22 № 06/567

Тамгай -ны № -т

Тайлбар мэдээлэл хүргүүлэх
тухай

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

О.Амаржаргал
Ажлын газар

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оновчтой гэж үзсэн бүтцийн саналыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд Засаг даргын зүгээс өргөн барьж зөвшилцөн 2013 оны 01 дүгээр сарын 18-нд орон тооны хязгаар, албан тушаалын бүтцийг шинэчилсэн байдаг.

Тухайн үед Зуунмод сумын онцлогийг харгалзан дараах нөхцөл байдлыг авч үзсэн болно.
Үүнд:

1. Сумын хэмжээнд 20 гаруй мянган малтай ч, бусад сумын нутагт байрлаж, зарим малчид мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг тухайн сумаас авч байгаа.
2. 1900 гаруйхан га нутаг дэвсгэртэй тул малын бэлчээр байхгүй, газар тариалан эрхлэх бололцоо муутай.
3. Улмаар МЭҮТ-ийн ажлын ачаалал олон малтай бусад сумаас харьцангуй бага.
4. Хувийн мал эмнэлэг, үржлийн хоёр нэг үйл ажиллагаа явуулж байгаа тул мэргэжилтнүүдийн оролцоо бага.
5. Өөрийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуй, хүлэмжийн аж ахуйг түлхүү хөгжүүлэхэд анхаарч Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан.

Иймд тус тасгийн үүрэг чиглэлд багтаж байсан хоршоо, нөхөрлөл, жижиг дунд үйлдвэрлэл зэрэг асуудлыг Захирагчийн ажлын албаны худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтний үүрэг чиглэлтэй нэгтгэсэн ба мал эмнэлэг, үржил, газар тариалан хариуцсан ганц ХАА-н мэргэжилтэн ажиллахаар зохион байгуулсан.

Гэвч өнгөрсөн хугацаанд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас аудит хийгдэн танай аудитын адил Засгийн газрын 2010 оны 223-р тогтоолыг зөрчсөн тухай дүгнэлт ирүүлсэн юм.

Хэдий тус аймгийн төвийн сумын онцлог байвч эрх зүйн актуудад нийцэж ажиллах шаардлагатайг хүлээн зөвшөөрч МЭҮТ-ийг дахин байгуулах Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу бүтэц, орон тооны хязгаарт багтаан үүрэг чиглэлийг зөв зохион байгуулахаар бэлтгэн ажиллаж байна.

ДАРГА



Ж.ГАНБАТ



ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273539, Факс: 70273579

2014.03.18 № 01/02.
танай 2014.03.18-ны № 10/194-т

Хариу тайлбар хүргүүлэх тухай

О.Сосорт
Аудитор ашиглах
19/12.

1. Төв аймаг дах Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 09 тоотор "Сул орон тооны тухай" албан бичиг ирүүлсний дагуу 2013 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн а/005 дугаартай албан бичиг хавсралтын хамт Аймаг дах Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн.

Аймаг дах төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Отгонбаттай уулзаж зөвлөгөө авсан. Манай алба яаралтай мэргэжилтнүүдээ авахгүй бол энэ жилийн худалдан авах ажиллагаа оройтож байгаа бас 90 жилийн ойг тохиолдуулан их ажил хийгдэнэ.

Тиймээс өндөр шаардлага тавих юм бол танай зарласан ажлын байранд хүн орохгүй болох магадлалтай тул танай тавьсан шаардлагад нийцсэн нөөцөөс нөхөх хүмүүс байхгүй байгаа учраас төрийн албанд 1-ээс доошгүй жил ажилласан байх гэсэн шаардлагыг багасгаж ахлах мэргэжилтэн нь ня.бо эдийн засагч мэргэжилтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх, мэргэжилтэн нь эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх гэж багасгаад албан бичиг өгөх нь зүйтэй гэсний дагуу 2013 оны 04 дүгээр сарын 01-ний а/006 дугаартай албан бичгээр 3 мэргэжилтэний сул ажлын байранд тавигдах шаардлагыг өөрчилөн хүргүүлсэн юм.

2.Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг Худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн орон нутгийн нэгжийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын загварын дагуу гаргаж аймгийн Хяналт, үнэлгээ, шинжилгээ-дотоод аудитын албанаас зөвлөгөө авч боловсруулсан. Өөрсдийн томилох хүнийхээ ажлын туршлагад тохируулан боловсруулаагүй болно.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн албан бичгүүдийг хавсаргав.

ДАРГА

З.АМАРСАЙХАН

ТТССБ47 ± 3004502



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

213300 Зуунмод, Төв аймаг

Утас: Факс:

2014.09.22 № 232

талай 2014.09.19 -ны № 03/178 -т

Албан тоотын хариу

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

О.Амгунзайз
Аудитын газар
24/IX 2014г

Тус хэлтсийн бүтэц, орон тоо, албан хаагчдын ажлын чиг үүргийн байдалд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараахь тайлбарыг хүргүүлж байна: Үүнд

- 2009 оноос Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс байхдаа 46 орон тоотойгоор ажиллаж байсан (Хэлтсийн даргын 2009 оны бүтэц орон тоо батлах тухай 01 тоот тушаал)
- 2013 онд Салбар дундын мэдээллийн сан бий болгох түүнийг цаашид ашиглах, ӨАТТСудалгааг хийхээр 4 орон тоог шинээр баталж 50 болгосон. (нэмэгдсэн 4 орон тооны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт)
- 2013 оны цалингийн сан нэмэгдсэн нь 4 орон тоо, Төрийн албан хаагчын нэмэгдэлтэй холбоотой.
- Одоо ажиллаж байгаа сумын мэргэжилтэний 98 хувь нь НХҮХэлтэс байгуулагдахад ХХҮХэлтсээс шууд шилжин орж ирсэн. Манай хэлтэс нь АБТ-г боловсруулахад хэлтсийн болон Ерөнхий газрын хэтийн төлөвлөлттэй уялдуулж боловсруулдаг бөгөөд тухайн хүнд хандсан АБТ боловсруулсан байна гэсэн нь өрөөсгөл дүгнэлт гэж үзэж байна.

Сумын Нийгмийн халамжийн мэргэжилтэнг эхний удаа 3 шат, 2013 онд 2 шатны сургалтаар мэргэшүүлж байсан бөгөөд одоо ажиллаж байгаа мэргэжилтэнүүд нь ХАХНХЯам, Нийгмийн ажилтаны холбоо, Нийгмийн ажлын их дээд сургуулиудын мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан мэргэшсэн Нийгмийн ажилтаны сертификат бүхий ажилтанууд болно.

Жич: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн даргын тушаал, сум хариуцсан хөдөлмөр халамжийн мэргэжилтэнийн ажлын байрны тодорхойлолт, НХҮЕГазрын даргын тушаалын хуулбарыг хавсаргав.



ДАРГА

Д.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

213300 Зууниод, Төв аймаг

Утас: Факс:

2014.09.19 № 113
ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
2014.09.17 -ны № 05/176 -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

О.Анхбаяртай

Аудитын амжилт
22/IX 2014

Тоотын хариу

"Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, төрийн дээд байгууллагын шийдвэр, хэрэгжилт, төрийн захиргааны зардлыг бууруулах" сэдэвт нийцлийн аудитын хүрээнд төсөвт байгууллагуудын бүтэц, орон тоо, албан хаагчдын ажлын чиг үүргийн байдалд хийгдсэн аудитын шалгалтанд манай байгууллагатай холбоотой асуудалд дараах тайлбарыг өгч байна.

Аймгийн Засаг дарга нарт ирүүлсэн Соёл, Спорт, Аялал жуулчлалын сайдын 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 1а/1469 тоот зөвлөмжинд тусгагдсан

а/Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, спорт, аялал жуулчлалын газрыг зохион байгуулахдаа Төрийн албаны тухай хуулийн 27.2.3-т "төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан / нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх / эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал / ажлын байр / -ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг албан тушаалд нь үргэлжүүлэн ажиллуулах гэж заасныг чанд баримтлан асуудлыг шийдэх

б/Орон тоо төсвийг 2013 оны улсын төсвийн тухай хуульд нийцүүлэн зохион байгуулах, 2014 оноос орон тоо, зохион байгуулалтыг хавсралтын дагуу шийдвэрлэхэд анхаарах / Хавсралт1 / гэсэн дээрхи зөвлөмжийг удирдлага болгон аймгийн Засаг дарга нь "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай" хууль, "Төсвийн тухай" хуульд заасан аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын бэлтгэл сургалтын төвийг 2014 оны 01 дүгээр сарын 15 өдөр байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/464 тоот захирамжаар Соёл, спорт, аялал жуулчлалын газрыг 2013 оны 08 дугаар сарын 26-ны өдөр нь байгуулахад Биеийн тамир спортын хороо нь 24 хүний орон тоотой ажиллахаас 22 хүний орон тоотой ажиллаж байсан.

Соёл, спорт, аялал жуулчлалын газар нь 27 орон тоотойгоор ажилласанаар өмнөх оноос 6 орон тоогоор нэмэгдсэн. /Энэ нь байгууллагын дарга, төсвийн мэргэжилтэн, жижүүр -4 /

Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Сайдын 2013 оны 1а/1469 тоот зөвлөмжийг хавсрав.

ДАРГА

М.О.О.О.

Ш.ЭРДЭНЭЧУЛУУН



ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ХЭЛТЭС

41100, Зуушмод сум, Төв аймаг
Утас: 7027, Факс: 7027

2014. 09. 19 № 266
таний 2014. 09. 17 -ны № 03/123 -г

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

О.Амгунгараму

Аудитад амжиллаа

22/IX 2014

Тайлбар хүргүүлэх тухай

Тус газраас аудитын нэгдсэн тайланд оруулахаар манай байгууллагатай холбоотой тайлангийн төслийг ирүүлсэн байдалтай танилцан дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/24 тоот тушаалын дагуу тус хэлтсийг 28 орон тоотой байхаар баталснаас удирдах ажилтан-1, гүйцэтгэх ажилтан-18, үйлчилгээний ажилтан-9 байх бөгөөд 2013 онд нийт 27 орон тоотойгоор ажилласан нь орон тоо илүү ажиллах үндэслэл байхгүй, мөн хүний нөөц дотоод ажил хариуцсан мэргэжилтний орон тоог хавсран ажилласан болно.

Үүнд:

№	Батлагдсан орон тоо	Тухайн орон тоонд ажилласан албан тушаалтаны нэр	2013 оны хүний нөөцийн тайлбар
1	Дарга	1	Л.Болдбаатар
2	ХНДАХМэргэжилтэн	1	Э.Уянга Хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Э.Уянгын мэдлэг, ур чадвар, ажлын дэдлага туршлагыг харгалзан 2013 оны 4 дүгээр сарын 1-ний Б/25 тоот даргын тушаалаар байгууллагын хүний нөөц, дотоод ажлыг түр хавсруулан гүйцэтгүүлж байгаад 2013 оны 06-р сарын 07-ны өдрийн Б/41 тоот тушаалаар хүний нөөц дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэнээр томилсон.
3	ХШҮМэргэжилтэн	1	Э.Тунгалагтамир
4	Сан хариуцсан мэргэжилтэн	1	С.Эрдэнэцэцэг
5	Үйл ажиллагааны нягтлан	1	Ж.Эрдэнэчимэг
6	Бичиг хэрэг, архив, даргын туслах	1	Ч.Ундрахцэцэг
7	Нярав	1	Батчулуун

8.	Үйлчлэгч	1	Одгэрэл	
9.	Жолооч	1	Т.Ганбат	
	Жижүүр	1	Ю.Батсайхан	Хэлтсийн жижүүрээр 3.Баярмандахыг 2013 оны 10-р сарны 01-нээс Б/64 тоот тушаалаар ажилд авч, 2013 оны 10-р сарын 22-ны Б/66 тоот тушаалаар өдөр үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн тул ажлаас халж, Ю.Батсайханыг 2013 оны 10-р сарын 26 өдрийн Б/67 тоот тушаалаар жижүүрээр томилон ажиллуулсан.
10	ХЭБХХариуцсан ахлах мэргэжилтэн	1	С.Отгонхуяг	
11	НХАжил, жижиг зээл хариуцсан мэргэжилтэн	1	Э.Алтанзул	
12	МБСТХарилцааны мэргэжилтэн	1	Ж.Оюунцэцэг	
13	ХАБЭАМэргэжилтэн	1	Итгэлт	
14	Хөдөлмөрийн харилцааны мэргэжилтэн	1	Отгонбаатар	
15	ЖДҮБХэрэгжилт, төсөл хөтөлбөрийн мэргэжилтэн	3	О.Цэвэгцэрэн, Ж.Батчимэг, С.Гантөгс	
16	Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн мэргэжилтэн	3	Ц.Одмандах, Буянхишиг, П.Дэлгэрсүрэн	
17	АОДХ, ХБИХЭДХөтөлбөрийн мэргэжилтэн	1	Д.Оюундэлгэр	
18	ХЭНийтлэг үйлчилгээний ахлах мэргэжилтэн	1	Б.Эрдэнэбат	
19	Ажилд зуучлах үйлчилгээний мэргэжилтэн	2	Ч.Ундрал, Ч.Чулуунцэцэг	
20	АББМэдээллийн мэргэжилтэн	1		
21	ХЗЗМСан, статистикийн мэргэжилтэн	1	Р.Эрдэнэбат	
22	ТХСүлжээний мэргэжилтэн	1	Б.Батхишиг	
23	АМЧБаримжаа, зөвлөгөө өгөх үйлчилгээний мэргэжилтэн	1	Цэвэлсүрэн	
		27		

2. Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2014 оны 01-р сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар Аймаг дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталж тус хэлтсийг 28 орон тоотой, **гэрээт ажилтан 3** байхаар баталсан. Бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан 6 мэргэжилтнийг ажлаас чөлөөлж Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.1, 79.1, Төрийн албаны тухай хуулийн 27.2.4 дэх заалтууд, Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/12 тоот тушаалаар баталсан Аймаг дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дүрмийн 3.1.12 дах заалт, тус хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмын 4.2-ийг тус тус үндэслэн 6 ажилтанд хуулийн дагуу тэтгэмжийг олгосон.

3. Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2014 оны 01-р сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар Аймаг дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсан бөгөөд хүн амын тооноос нь хамааран 9 суманд сумдын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэнг орон тоогоор ажиллуулахаар болсон. Дээрх шийдвэрийн дагуу Баянчандмань, Жаргалант, Борнуур суманд төрийн албаны нөөцөд байгаа иргэдээс авч ажиллуулсан. Эрдэнэ, Бүрэн, Эрдэнэсант, Заамар, Алтанбулаг, Батсүмбэр сумдад тус хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайгч болон орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах боломжтой иргэдээс түр хугацаагаар орон нутгийн саналаар авч ажиллуулсан. Тус аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд 2014 оны 09-р сарын 02-ны өдрийн 113 тоот албан бичгээр дээрх сумдын албан тушаалын сул орон тоог зарлуулахаар хүргүүлсэн болно.

4. Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2014 оны 01-р сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар Аймаг дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсны дагуу Хөдөлмөрийн яамны 2014 оны 4/519 албан тоотор ажлын байрны жишиг тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн бөгөөд жишиг ажлын байрны тодорхойлолтод үндэслэн хэлтсийн бүх мэргэжилтэнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан бөгөөд мэргэшлийг тухайн ажилтанд тохируулан боловсруулсан гэх үндэслэл байхгүй гэж үзэж байна.

5. Тус хэлтсийн ажилд зуучлах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Чулуунцэцэгийг уг албан тушаалд Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 27.2.3 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 21-р зүйл заалт, болон Зуунмод сумын ЗДТГазарт Зуунмод сумын хөдөлмөрийн эрхлэлтийн асуудлыг хариуцан ажиллаж байсан, нийгмийн ажилтнаар олон жил орон нутагт ажилласан туршлага,

давуу талыг судлан хэлтсийн даргын 2013 оны 02-р сарын 14-ны өдрийн Б/11 тоот тушаалаар томилсон болно.

Ажил зуучлах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Чулуунцэцэгтэй холбоотой зөрчлүүд нь хувь хүний болон тус хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн нарын хайхрамжгүй байдлын улмаас үүссэн гэж үзэж илэрсэн зөрчлийн дагуу холбогдох арга хэмжээг авч, зөрчлийн талаарх залруулга, Ч.Чулуунцэцэгтэй холбоотой тушаал, шийдвэрийг эх хувиар нь хавсралтаар хүргүүлж байна.

Үүнд:

-Ч.Чулуунцэцэгийн Регистрийн дугаар: ню64122289 /цахим үнэмлэхийг хавсралтаар/

-Төрийн албанд тангараг өргөсөн хугацаа нь 2009 оны 11-р сарын 25 /захирамжийг хавсралтаар/

-Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл 5 хувь /тушаалыг хавсралтаар/

Хавсралт 2 хуудастай

ДАРГА



Л.БОЛДБААТАР